

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Нямсүхийн Батзаяа	Дугаар	L326
Оршин суугаа аймаг	Өвөрхангай	Оршин суугаа сум	Хужирт сум
Төрсөн газар	Хужирт сум	Төрсөн он	1981
Ажил мэргэжил	Ловон лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Илдэн бэйлийн хүрээний Халуун усны хийд	Сүм хийдийн дугаар	ӨХХУ 014
Одоогийн сүм хийд	Ганданпэлжээлин	Сүм хийдийн дугаар	ӨХХУ 015
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 5-р сарын 28	Ярилцлага авсан хүн	Жужа



Өвөрхангай аймгийн Хужирт сумын Илдэн бэйлийн хүрээний Халуун усны хийд болон Ганданпэлжээлин хийд
Жужа: Танай хийд хэдэн онд байгуулагдсан бэ?

Батзаяа: 1992 онд байгуулагдсан. Хуучин эмнэлгийн байшин байсан байранд хүрж байгаад 1995 онд энэ дуганыг шинээр босгосон.

Жужа: Энэ хийд шинээр байгуулагдсан хийд үү, сэргээсэн хийд үү?

Батзаяа: Манай хийдийн гарал үүсэл бол Илдэн бэйлийн хошууны хүрээний ая дан, дэг жаягийг сэргээн залгамжлан авч яваа хийд ээ.

Жужа: Энэ шинэ дуганыг хэний санаачилгаар босгосон бэ?

Батзаяа: Доктор Чой.Лувсанжав, лам Пэрэнлэйлхүндэв гээд олон хүмүүс оролцсон. Голлох хүмүүс нь дээрх хоёр хүн юм аа.

Жужа: Шинээр анх байгуулагдахад хэдэн ламтай байсан бэ?

Батзаяа: 12 өвгөн лам, энд бүртгэл нь байгаа. 12 өвгөн лам бол илдэн бэйлийн хүрээнд сууж байсан лам нар. Тэгээд 13 лам бандитай, 1992 онд хурлаа эхэлсэн.

Жужа: Энэ шинэ дуганы нэр юу вэ?

Батзаяа: Тэр урд байгаа дуганд бол одоогоор тодорхой нэргүй. Бараг улсын бүртгэлд ч ороогүй.

Жужа: Хуучин Илдэн бэйлийн хүрээнээс хадгалагдаж үлдсэн ямар нэгэн шүтээн бий юу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Батзаяа: Бий. За тэр хоймор байгаа голын шовгор малгайтай баримал бол манай Илдэн бэйлийн хүрээний анхны хувилгаан Агваандамбын лагшин дүр. Энэ хүн бол их том бичиг номын хүн байсан. Одоо хоёр том боть ном бичсэн. Манай хийдэд одоо гар бичмэл нь бүрэн эхээрээ хадгалагдаж байна. 1992 онд доктор Чой.Лувсанжав гуай энд авчирч залсан. Бусад өөр жижиг бурхад шүтээн бол уламжилж ирсэн шүтээн биш, шинэ сүүлийн үеийн бурхан шүтээн. Харин манай хийдэд Төвхөн хийдийн гол шүтээн нь байсан.1996 онд Төвхөн хийдийг сэргээн байгуулагдахад байх газраа байх ёстой гэж үзээд тэнд аваачиж залсан.

Жужа: Тэр ямар шүтээн байсан бэ?

Батзаяа: Өндөр гэгээн өөрөө өөрийгөө бүтээж урласан гэх шуумал өндөр гэгээн. За тэр бол одоо цорын ганц байдаг өндөр гэгээний өөрийн хосгүй үнэт бүтээл. Түүхийг нь яривал товчхондоо өндөр гэгээн Галдан бошигтоос зугтааж зүүн тийшээ явах болжээ. Тэгэхэд шавь нар нь бид нар оройдоо хэнд мөргөж залбирч байх вэ гэсэнд өндөр гэгээн өөрөө өөрийнхөө дүрийг бүтээж үлдээсэн юм гэнэ лээ. Тэргүүн дээрээ тийм баринтагтай, жанлавцогзол номыг барьсан ийм шуумал дүр. Харин манайд байхдаа яг тэр хэвээрээ байдаг байсан. Төвхөнд очсон хойноо баринтагтай номыг нь аваад өмнө нь дор нь тавьчихсан байна лээ. Одоо Төвхөнд очоод харах юм бол харна.

Жужа: Танай хийд ямар ямар уншлага хурж байна вэ?

Батзаяа: За манайх Илдэн бэйлийн хүрээний цогчин уншлагыг үг үсэггүй яг тэр хэвээр нь тэр ая дангаар нь уншиж байна. Анх шинээр сэргээхэд манай дархан унзад байсан өвгөн Илдэн бэйлийн хүрээнд сууж байсан учраас хуучин цогчинг яг тэр хэвээр нь дамжуулсан. Мөн зуны эхэн сард сүсэгтэн олонд тахил гэж нэг том хурал хурдаг. Энэ хурлыг Төвдэд ганцхан хийдэд, монголд бас ганцхан манай хийдэд л хурдаг юм. Бусад хурлуудын тухайд сүм хийдүүдийн нэгэн адил шинийн найманд, шинийн 15-нд энэ тэр гээд энд биччихсэн байгаа.

Жужа:Хүрээг хэдэн онд хаасан бэ?

Батзаяа: 1937 онд хаасан.

Жужа: Тэр анхны арван хоёр өвгөн ламаас одоо ямар хүмүүс байна вэ?

Батзаяа: Бараг бүгд таалал болсон. Одоо Илдэн бэйлийн хүрээний сүүлчийн ганц хувраг гэх Бат-Очир гэдэг өвгөн лам хотод ламиран дацанд сууж байна. Манай энэ багшийн зиндаанаас хоёр зиндаа доош байсан гэдэг юм билээ. Тэр хүн л амьд үлдсэн цорын ганц хүн байна. Манай энд хуралд хааяа хааяа ирж суудаг өвгөн лам бий. Тэр 3 бол яг Илдэн бэйлийн хүрээнд байгаагүй лам нар.

Жужа: Халуун усны хийдийн лам нараас хүн бий юу?

Батзаяа: Халуун ус гэдэг чинь халуун рашаан л юм. Тэнд ирсэн рашаанчдад хурал хурдаг байсан юм гэнэ лээ. Гэхдээ лам нар нь энэ Илдэн Бэйлийн хүрээнээс очдог байсан юм гэсэн.

Жужа: Халуун усны хийд хэдэн дугантай байсан?

Батзаяа: Нэг дугантай, Чойдогжав гэж ловон, Жигмэд унзад гэж хоёр хүн байсан юм гэнэ лээ.

Жужа: Хийдийн сахиус нь юу байсан юм бол?

Батзаяа: Манал. Харин Яргайтын сүмийн сахиус Жамсран юм гэнэ лээ.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа Одоо танай хийд хэдэн ламтай вэ?

Батзаяа: Шинэ хийд

маань 11 ламтай. Хоёр нь зүйл суманд шинээр сэргээж буй хийд рүү явсан. Тэнд Далай гүний хүрээг сэргээх юм гэнэ лээ. Сая 4 сарын 2-нд нээлтээ хийсэн. Лүндээжанцан гишүүн , төмөр замын орлогч дарга Наранхүү гэдэг хоёр хүний санаачилга хандиваар босгож байгаа гэсэн. Энэ их хурлын гишүүдэд нэг хэлтэй амтай мөнгө тойрогт нь хуваарлиж тараадаг ш дээ.Түүнээсээ л өгч байгаа юм гэсэн.

Жужа: Танай лам нарын дотор цол хэргэмтэй лам бий юу?

Батзаяа: Яг ном ёсны одоо чойрын ч гэх юм уу, цол мяндагтай лам байхгүй. Албан тушаалын хувьд гэсгүй нэг, унзад лам нэг, ловон лам нэгтэй.

Жужа: За одоо өдөр тутам ямар хурал хурж байна вэ?

Батзаяа: Цогчингоо хурна. Шинийн найманд манал хурна. Шинийн 15-нд найдан чог хурна.Битүүнд ламиран эсвэл дарь эхийн чогийг ээлжилж хурна. Хорин есөнд арван хангал хурж сахиусаа тахина.За дуганд 2 ганжууртай. Нэгийг нь айлуудаар залж явдаг. Нэг нь айлтгалын ганжуур.

Жужа: Жилийн хурал ямар хуралтай вэ?

Батзаяа: Хаврын эхэн сарын нэгнээс арван таванд оройн ерөөл, зужны эхэн сарын шинийн гурванд санжидмоллом. Намрын дунд сард майдар.Тэгээд бурхан багшийн дүйчэн өдрүүдэд тогтмол хурдаг.

Жужа: Танай хийдээр хэр олон хүн үйлчлүүлж байна?

Батзаяа: Жилдээ 6000 орчим хүн хурал хуруулдаг гэсэн дундаж тооцоо гаргасан байдаг.

Жужа: Одоо ямар хурал хурж байна?

Батзаяа:Одоо тахил хурж байна. Би дээр хэлсэн. Монголд ганцхан манай хийдэд хурдаг хурал. Төвдэд бас ганцхан хийдэд хурдаг,Урд манай хийдийн Агваандондов гэж лам Төвд яваад эргэж ирэхдээ энэ хурлыг хийддээ залсан юм гэнэ лээ.

Жужа: Та хэдэн онд төрсөн бэ?

Батзаяа: 1981 онд төрсөн.

Жужа: Энэ хоёр суваргыг хэзээ босгосон юм бэ?

Батзаяа: Тэр өмнөх суваргыг 1995 онд босгосон. Дээд талынхыг 2002 онд босгосон юм. Бас 2004 оноос эхлэн манай хийдэд жил бүр Ирландаас Ванчин Ойдов ринбүүчи заларч ирдэг. Тэр хүнээс бас бид их юм заалгана. Энэ шинээр баригдаж байгаа дуган ямар нэгэн төсөл , хандиваар биш яг өөрсдийнхөө санхүүжилтээр явж буй учир барилгын ажил их удаашрилтай байгаа юм.

Жужа: За баярлалаа.